Этүгэн их сургуулийн нэгдүгээр дамжааны ёс зүйн багц хичээлүүдийн сэтгэл ханамжийн судалгаа

Б.Дүүрэнзул[1], Н.Нарантуяа[1], Б.Оюунцэцэг[1], Б.Батсэрээдэнэ[1], Б.Оюунгоо[2]

[1]ЭИС, Сувилахуйн сургууль
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: duurenzul.b@etugen.edu.mn, Утас: 99659438

Түлхүүр үг:

Сургалтын чанар
Харилцаа
Хандлага
Төлөвшил

Товч утга:

Үндэслэл: Даян дэлхийн 21-р зууны хөгжлийн хөтөлбөрт тэмдэглэхдээ “Боловсрол нь хүмүүст тогтвортой хөгжилд шаардагдах байгаль орчны болон ёс зүйн мэдлэг ур чадвар биеэ авч явах хүмүүжил, харилцааны ёс зүйг эзэмшүүлэх ёстой” гэжээ[1]. Этүгэн их сургууль нь 2006 оноос хойш ёс зүйн багц хичээлүүдийг зааж эхэлсэн бөгөөд 2017 оноос эхлэн ур дүнд суурилсан сургалт, 19 ур чадварыг хэрэгжүүлж эхэлсэн. Сургалтын чанарт өгөх оюутнуудын сэтгэл ханамжийг бид чухалчилсан юм. **Зорилго:** Этүгэн их сургуулийн нэгдүгээр дамжааны оюутнуудын баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлийн сэтгэл ханамжийг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгааг нэг агшингийн дескриптив загвараар чанарын судалгааны аргыг ашиглан гүйцэтгэж, сэтгэл ханамжийн асуулт тус бүрт Ликертийн хэмжүүрээр 1-5 хүртэл оноогоор үнэлүүлэв. 2022-2023 оны хичээлийн жилийн нэгдүгээр дамжааны 1102 оюутнуудаас ерөнхий хэсэг 3, үндсэн 17 асуулт бүхий судалгааны асуумжийг УМС-ийг ашиглан цахимаар авч үр дүнг IBM SPSS 22 excel программ ашиглан тооцов. **Үр дүн:** Судалгаанд хамрагсдын сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт нь баримжаа олгох хичээл 86.5%, мэргэжлийн удиртгал хичээл 87.1%, хичээлийн агуулгын уялдаа хамаарлыг үнэлэхэд 81% маш сайн, сайн гэж үнэлсэн байна. Судалгаанд хамрагсад хичээл судалсны дараа өөрт гарсан өөрчлөлтүүдээ нэрлэхэд мэргэжлийн талаарх ойлголт, цахим орчинд ажиллах чадвар, бие даах чадвараа ахиулсан, хувийн ариун цэвэр сахих байдал зэргүүд 50-аас дээш хувиар ахисан бөгөөд мэдлэг, чадвар, хандлагыг 80.3% хангалттай олгосон гэж үнэлжээ. **Дүгнэлт:** Нийт судалгаанд хамрагсдын сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт нь 86.8%, салбар сургуулиудын баримжаа олгох хичээл, мэргэжлийн удиртгал хичээлүүдийн дундаж сэтгэл ханамжийг судлахад эрүүл мэндийн сургууль 88.1%, сувилахуйн сургууль 90.5%, нүүр амны сургууль 83%, эмзүйн сургууль 92.3%, инженерчлэл эдийн засаг менежментийн сургууль 86%-тай үнэлсэн (p=0.62) нь статистик ач холбогдолтой, оюутнуудад өгөөжтэй, үр дүнтэй байлаа.

Үндэслэл: Судлаач Деннис Томсон “Ёс зүйн боловсрол хэмээх ойлголт зөвхөн төлөвшсөн сайн иргэн, сайн хүн болгон боловсруулах гэдэг ойлголтоос хальж бодит амьдралын тухайн нөхцөл байдал бүрт ёс зүйн шинжилгээ хийх, ёс зүйтэй, зарчимтай шийдвэр гаргаж чадах чадвартай иргэн, мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд шаардлагатай” байгааг дурджээ[1].

ЮНЕСКО-ийн Инчеоны тунхаглалд “Чанартай боловсрол нь бүтээмж болон мэдлэгийг дэмжин хөгжүүлж, бичиг үсэг, математикт суралцахтай ижил задлан шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, танин мэдэхүйн, хувь хүний хөгжил, ёс суртахуун, харилцааны чадваруудыг хөгжүүлдэг” гэдгийг онцлон тэмдэглэсэн байна[2].

Судлаач Ramakrishna Gollagari (2022) нарын “Этиоп улсын төрийн их сургуулиудын ёс зүйн манлайлал ба оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа”-нд Ёс суртахууны агуулгаар манлайлал, бие хүний зан

үйлийг заасан нь оюутнуудын сэтгэл ханамжид эергээр нөлөөлдөг болохыг судалгаагаар тогтоожээ. Түүнчлэн дээд боловсролын байгууллагуудын сургалтын агуулгад ёс зүйн манлайлал ба оюутнуудын сэтгэл ханамжийн хоорондын харилцаанд анхаарч ажиллахыг зөвлөсөн байна[3].

Шведийн эрдэмтэд ёс зүйн сургалтанд дескритив ёс зүй, ёс суртахууныг дэмжих хандлага, философийн ёс зүйн хандлага хамгийн чухал гэж үзсэн байна. Тэд ёс зүйн сургалтын ач холбогдлыг тодорхойлохдоо амьдралын чанар, нийгэмшил, арга хэрэгсэл гэсэн гурван үндэслэлийг дэвшүүлж, сургууль нь суралцагчдад ёс зүйг заах хэрэгтэй гэж дүгнэсэнтэй санал нэг байна[4].

Оюутны боловсролын үйлчилгээнд сэтгэл хангалуун байх нь дэлхий дахинд дээд боловсролын байгууллагууд оюутнуудыг татах хамгийн чухал стратегийн хүчин зүйлүүдийн нэг гэж тооцогддог учраас боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд хийгддэг боловсролын чанарт өгөх оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны ажлууд тасралтгүй хийгдсээр байна. Ийм учраас оюутнуудын ёс зүйн багц хичээл болох баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдийг судалж дууссаны дараа уг багц хичээлд өгөх оюутны сэтгэл ханамжийг судлах нь бидний судалгааны үндэслэл болсон юм.

Зорилго: Этүгэн их сургуулийн нэгдүгээр дамжааны оюутнуудын баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлийн сэтгэл ханамжийг үнэлэх.

Зорилт:

1. Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдийн агуулгыг оюутнуудын сэтгэл ханамжтай уялдуулан судлах
2. Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдийг салбар сургуулиудын оюутнуудын сэтгэл ханамжаар нь харьцуулан судлах

Арга, аргачлал: Судалгааг нэг агшингийн дескриптив загвараар чанарын судалгааны аргыг ашиглан гүйцэтгэж, сэтгэл ханамжийн асуулт тус бүрт Ликертийн хэмжүүрээр 1-5 хүртэл оноогоор үнэлүүлэв. Нэгдүгээр дамжааны 1102 оюутнуудаас ерөнхий хэсэг 3, үндсэн 17 асуулт бүхий судалгааны асуумжийг УМС-ийг ашиглан цахимаар авав. Үнэлгээний хэсгээс маш сайн, сайн, дундыг түүвэрлэж, үр дүнг IBM SPSS 22 excel программ ашиглан тооцов.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 1-р дамжааны 1102 оюутнуудын 25.8% (282) эрэгтэй, 74.2% (818) эмэгтэй байв.

Этүгэн их сургуулийн салбар сургуулиудын нийт 1102 оюутан хамрагдсанаас 26% нь Эрүүл мэндийн сургууль, 24% нь Эм зүйн сургууль, 13% нь Нүүр ам судлалын сургууль, 25% Сувилахуйн сургууль, 12% нь инженерчлэл эдийн засаг менежментийн сургуулиудын оюутнууд тус тус хамрагдсан бөгөөд нийт сэтгэл ханамж 86.8%, тус хичээлээр 19 ур чадварыг дэмжиж буйг үнэлсэн оюутны үнэлгээ нь 82%-тай байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсдын сэтгэл ханамж

Хичээлийн жил	Хамрагсдын сэтгэл ханамж		
	N	Хувь	19 ур чадвар
2022-2023 он	1102	86.8%	82%

Судалгаанд нийт хамрагсад баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээл судалсны дараа өөрт гарсан өөрчлөлтүүдээ нэрлэхэд мэргэжлийн талаарх ойлголт 62%, цахим орчинд ажиллах чадвар 61%, бие даах чадвараа ахиулсан 52%, хувийн ариун цэвэр сахих байдал 52%-иар нэмэгдсэн бол бичгийн хэв, хэмнэлт гамналт хийх, анхааралтай сууж сурсан үзүүлэлтүүд бага буюу 20 орчим хувиар нэмэгдсэн байдал нь статистик ач холбогдол бүхий байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээл судалсны дараах гарсан өөрчлөлтүүд

№	Гарсан өөрчлөлт	Тоо (n=1102)	Хувь	p утга
1	“Өглөөний хүн” болсон	330	30%	0.001
2	Цаг баримталдаг болсон	484	44%	0.35
3	Анхааралтай сууж сурсан	231	21%	0.01
4	Бие даах чадвараа ахиулсан	573	52%	0.06
5	Бичгийн хэв сайжирсан	187	17%	0.005
6	Эмх цэгцтэй болсон	430	39%	0.01
7	Ёс зүйн мэдлэг дээшилсэн	253	23%	0.07
8	Халатаа зөв өмсөж сурсан	451	41%	0.03
9	Хувийн ариун цэвэр	573	52%	0.043
10	Мэргэжлийнхээ талаар ойлголтоо ахиулсан	683	62%	0.17
11	Эерэг хандлага төлөвшсөн	375	34%	0.35
12	Мэргэжилдээ дуртай болсон	528	48%	0.61
13	Сургуулийн соёл эзэмшсэн	265	24%	0.41
14	Амжилттай суралцах арга барилаа ахиулсан	418	38%	0.02
15	Хэмнэл, гамналт хийж сурсан	209	19%	0.003
16	Ярих, илтгэх чадвар	341	31%	0.19
17	Цахим орчинд ажиллах чадвар ахисан	672	61%	0.57

Судалгаанд оролцсон 1102 оюутны сэтгэл ханамжаар 5R-ийн зарчмыг хичээлдээ үр дүнтэй ашигладаг нь 72.2%, хичээлүүдээр өгсөн даалгавар, бие даалтууд үр дүнтэй байсан 75.2%, тус хичээлүүдээр хангалттай мэдээлэл авсан 86%, мэдээллээ мэдлэг болгосон 92%, мэдлэгээ өөрийн болгож хэрэгжүүлсэн 88%, мэдлэг, чадвар, хандлагыг хангалттай олгосон 80.3%, хичээлүүдийн агуулгын уялдаа хамаарлыг 81%, багшийн заах арга зүй 92.5%-тай тус тус үнэлсэн байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд оролцогсдын сэтгэл ханамжийн үзүүлэлтүүд

№	Үнэлгээ / Олгож буй мэдлэг, чадвар	Маш сайн, сайн		Дунд	
		n	%	n	%
1	Та 5R-ийн зарчмыг хичээлдээ үр дүнтэй ашиглаж чадаж байгаа эсэх	796	72.2%	222	20.2%
2	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдээр өгсөн даалгавар, бие даалтууд үр дүнтэй байсан эсэх	829	75.2%	242	22%
3	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлээр хангалттай мэдээлэл авсан эсэх	948	86%	121	10.9%
4	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлээр олгосон мэдээллээ мэдлэг болгож чадсан эсэх	1014	92%	44	4%
5	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлээр олж авсан мэдлэгээ хэрэгжүүлж чадсан эсэх	970	88%	80	7.2%
6	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдийн агуулга танд хангалттай мэдлэг, чадвар, хандлагыг олгосон эсэх	885	80.3%	203	18.4%
7	Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал, хичээлүүдийн агуулгын уялдаа хамаарлыг үнэлэх	893	81%	138	12.5%
8	Багшийн заах арга зүй	1020	92.5%	72	6.5%

Баримжаа олгох, мэргэжлийн удиртгал хичээлүүдийг судалсан оюутнуудын сэтгэл ханамжийг салбар сургуулиудаар гаргахад Эрүүл мэнд, Сувилахуй, Эмзүйн сургуулиуд нь дунджаас дээгүүр үнэлгээтэй ($p=0.01$) буюу агуулгыг олгож байна. Харин Нүүр амны судлал, Инженерчлэл эдийн засаг менежментийн сургуулиуд нь дунджаас доогуур ($p=0.000$) буюу агуулга бүрэн олгогдохгүй байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Этүгэн салбар сургуулиудын оюутнуудын сэтгэл ханамжийн байдал

Хичээл Сургууль	Баримжаа олгох		Мэргэжлийн удиртгал		Дундаж	
	Тоо (n)	Хувь (%)	Тоо (n)	Хувь (%)	Тоо (n)	Хувь (%)
Эрүүл мэндийн сургууль	977	88.7%	964	87.5%	970	88.1%
Сувилахуйн сургууль	980	89%	1013	92%	996	90.5%
Нүүр амны сургууль	892	81%	937	85%	914	83%
Эмзүйн сургууль	945	92.7%	1013	92%	979	92.3%
Инженерчлэл эдийн засаг менежментийн сургууль	892	81%	870	79%	881	80%

Хэлцэмж: Судлаач Marzieh Shayestehfard (2004) "Үр дүнд үндэслэн ёс зүйн мэдрэмжийн сургалтаар практик онол, сэтгэн бодох аргыг хөгжүүлэх, даалгаварт суурилсан арга барилыг түлхүү ашиглаж сэтгэл ханамжийг судлахад үр дүн 92%-тай байгаа нь бидний судалгааны ажлын үр дүнтэй ойролцоо байна[5].

Судлаач Hee-Kyung Joh (2009) "Эмнэлгийн ёс зүйн боловсролын хөтөлбөрийн хүрээнд жижиг бүлгийн ярилцлага, асуумж судалгааны дараа оюутны сэтгэл ханамж, өөрийгөө үнэлэх" судалгаанд нийт 121 оюутнууд хамрагдсан бөгөөд үр дүнд сэтгэл ханамж, өөрийн үнэлгээ 87%-тай өндөр байгаа нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна[6].

Судлаач Hattori Kenji (2007) Ёс зүйн хичээлийн сэтгэл ханамжийн судалгаанд 2000 оны хичээлийн жилд нэгдүгээр дамжааны 85 оюутны 72 нь (84.7%) сэтгэл ханамжтай нь бидний судалгаатай дүйж, 2001 оны хичээлийн жилд нэгдүгээр дамжааны 85 оюутны 47 нь (55.3%) сэтгэл ханамжтай гэж дүгнэсэн нь манай судалгааны үр дүнгээс ялгаатай байлаа[7].

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагсдын сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт нь 86.8% бөгөөд баримжаа олгох хичээл 86.5%, мэргэжлийн удиртгал хичээл 87.1%, хичээлийн агуулгын уялдаа хамаарлыг үнэлэхэд 81% маш сайн, сайн гэж үнэлжээ. Судалгаанд хамрагсад хичээл судалсны дараа өөрт гарсан өөрчлөлтүүдээ нэрлэхэд мэргэжлийн талаарх ойлголт, цахим орчинд ажиллах чадвар, бие даах чадвараа ахиулсан, хувийн ариун цэвэр сахих байдал зэргүүд 50-аас дээш хувиар ахисан мөн мэдлэг, чадвар, хандлагыг 80.3% хангалттай олгосон гэж үнэлсэн нь энэхүү хичээлүүдийг цаашид үргэлжлүүлэн заах нь оюутнуудад ихээхэн ач холбогдолтой байна.
2. Салбар сургуулиудын баримжаа олгох хичээл, мэргэжлийн удиртгал хичээлүүдийн дундаж сэтгэл ханамжийг судлахад эрүүл мэндийн сургууль 88.1%, сувилахуйн сургууль 90.5%, нүүр амны сургууль 83%, эмзүйн сургууль 92.3%, инженерчлэл эдийн засаг менежментийн сургууль 86%-тай үнэлсэн (p=0.62) нь статистик ач холбогдолтой, оюутнуудад өгөөжтэй, үр дүнтэй багц хичээлүүд байв.

Ном зүй:

1. *Дарьхүү.Р Монголд дахь ёс зүйн боловсролын асуудлууд. Улаанбаатар 2017. х.32 дахь тал*
2. *Лхам.И., Уянга.Г., Сургууль ёс суртахууны боловсрол, хүмүүжлийн төв болох нь Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Улаанбаатар 2016 х.77-78 дахь тал*
3. *Ramakrishna Gollagari., Ethical Leadership and Students' Satisfaction in Public Universities of Ethiopia., Published online: 07 Mar 2022., doi.org/10.1080/01900692.2022.2044859*
4. *Victor Gardellia., Why philosophical; ethics in school implications for technology and in general. Ethics and Education, 9:116-28, dio:10.1080/17449642.2014.8902*
5. *Farideh Namadi, Masumeh Hemmati-Maslakpak., The effects of nursing ethics education through case-based learning on moral reasoning among nursing students., DOI: 10.4103/NMS.nms_33_18*
6. *Hee-Kyung Joh, Jwa-Seop Shin., Student satisfaction and self-assessment after small group discussion in a medical ethics education program., Korean J Med Edu 2009 Sep;21(3):243-57. doi:10.3946/kjme.2009.21.3.243. Epub 2009 Sep 30.*
7. *Kenji Hattori., An Approach to Student-Oriented Educational Program of Medical Ethics 2002 年 52 巻 2 号 p. 99-106 doi:org/10.2974/kmj.52.99*

Etugen university first grade ethical course satisfaction survey

Duurenzul B[1], Narantuya N[1], Batsereedene B[1], Oyuntsetseg B[1], Oyungoo B[2]

[1]Nursing school, Etugen University
[2]Nursing school, MNUMS
E-mail: duurenzul.b@etugen.edu.mn, Tel: +976-99659438

Background: At the "21st-century development program of the world" conference, he said, "Education should teach people the environmental and ethical knowledge, skills, behavior, and communication ethics that are required for sustainable development." Etugen University has implemented a series of ethical lessons and outcome-based programs since 2006 and 2017, respectively. Therefore, there is a need for evaluating the satisfaction of students with these programs.
Aim: The assessment from freshmen enrolled for the 2022-2023 academic year from the professional introduction and orientation programs.
Materials and Methods: A total of 1st grade 1102 students answered the questionnaire that has 3 general parts and 17 main questions. Data analyses were performed using Microsoft Excel and SPSS software.
Results: The average level of satisfaction of the participants in the study was 86.5% for the orientation course, 87.1% for the professional introduction course, and 81% for evaluating the coherence of the course content as very good or good. In the study, when the participants named the changes that happened to them after studying the course, they improved their understanding of the profession, their ability to work in the online environment, their self-reliance, their level of personal hygiene improved by more than 50%, and 80.3% rated their knowledge, skills, and attitudes as satisfactory.
Conclusions:

1. An average of 86.8% of participants answered with very good scores. This includes 85.5% for general orientation and 84.5% for professional orientation. The correlation between general vs professional orientation was evaluated by 81% of participants as good to very good. Present survey releases that over 50% of improvements in understanding of their profession, their ability to work in an online environment, self-confidence, and personal hygiene following skills after the courses. Participants evaluated that acquired 80.3% of their knowledge, skills, and attitude.
2. Average satisfaction with orientation programs and professional introductory courses by schools was - 88.1% in the school of health, 90.5% in the school of nursing, 83% in the school of dentistry, 92.3% in the school of pharmacy, 86% in the school of engineering, economics, and management - statistically significant (p=0.62) and useful and effective for students.

Keywords: Teaching quality, Attitude, Communication, Decent